

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын
арван дөрөвдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: ОРА-2025/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас:70353088, Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805, Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70357955, Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 69
танай _____-ны № _____-т

Г ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН АРВАН ДӨРӨВДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.БОЛДСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ерөнхий боловсролын арван дөрөвдүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын ерөнхий газраас 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01/6148 дугаар албан тоотор аймгийн Засаг даргын Тамгын газарт чиглэл хүргүүлсний дагуу ерөнхий боловсролын сургуулиудад гал тогооны түрээслэгч аж ахуй нэгжийн гэрээг дуусгавар болгож, сургуулийн хэмжээнд хоол үйлдвэрлэл үзүүлэх ажиллагааг зохион байгуулсан байна.

Үүний зэрэгцээ нийтийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж 93,045.58 мянган төгрөгийн өөрийн орлого бүртгэж, 66,135.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 1 хүүхдэд 1385 төгрөгөөр үдийн хоолны зардлыг нэмэгдүүлснээр орон нутгийн төсвөөс 169,086.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,906,202.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 108,199.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 14,952.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 412,469.5 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 425,950.5 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Бусад асуудал

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 233 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсролын газрын даргатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг 98.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	656,026,015.57	951,513,015.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	425,950,465.99	664,930,313.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	425,950,465.99	664,930,313.77
3121	Төгрөг	425,950,465.99	664,930,313.77
31211	Төрийн сангийн харилцах	425,930,465.99	664,910,313.77
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	20,000.00	20,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	230,075,549.58	286,582,702.03
351	Түүхий эд материал	202,768,558.58	245,601,161.03
35110	Тусгай зориулалттай материал	202,363,958.58	245,357,311.03
35130	Эм боох материал	404,600.00	243,850.00
354	Хангамжийн материал	27,306,991.00	40,981,541.00
35410	Бичиг хэргийн материал	4,264,900.00	7,924,650.00
35420	Аж ахуйн материал	20,631,091.00	27,734,691.00
35450	Барилгын засварын материал	2,411,000.00	3,740,200.00
35460	Хүнсний материал	-	1,582,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,361,624,027.23	8,488,740,127.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,361,624,027.23	8,488,740,127.54
392	Биет хөрөнгө	7,870,111,527.32	7,998,147,627.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,641,861,261.00	6,675,072,434.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(781,409,718.38)	(951,404,620.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	885,974,225.92	1,202,551,262.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(357,446,597.78)	(486,694,855.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	407,910,623.92	444,684,539.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(160,818,462.07)	(196,475,061.75)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,093,291,115.00	1,093,291,115.00
39217	Ном	140,749,079.71	217,122,813.71
393	Биет бус хөрөнгө	491,512,499.91	490,592,499.85
39301	Програм хангамж	9,054,860.00	9,754,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,542,360.09)	(6,162,360.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	487,000,000.00	487,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,017,650,042.80	9,440,253,143.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	7,180,356.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,180,356.00
413	Өглөг	-	7,180,356.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	7,180,356.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,017,650,042.80	9,433,072,787.34
51	Засгийн газрын хувь оролцоо	9,017,650,042.80	9,433,072,787.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,374,640,377.37	4,374,640,377.37
512	Хуримтлагдсан үр дүн	88,138,084.49	503,560,829.03
51210	Өмнөх үеийн үр дүн	88,138,084.49	88,138,084.49
51220	Тайлант үеийн үр дүн	-	415,422,744.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,554,871,580.94	4,554,871,580.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,017,650,042.80	9,440,253,143.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,109,605,698.86	5,713,199,964.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	352,630,098.86	698,797,664.00
120	Нийтлэг татварын бус орлого	352,630,098.86	698,797,664.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	334,872,853.86	683,845,464.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,115,200.00	4,864,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,158,110.00	412,469,462.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	308,599,543.86	266,512,002.00
120009	Бусад орлого	17,757,245.00	14,952,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,756,975,600.00	5,014,402,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,666,370,500.00	4,906,202,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,666,370,500.00	4,906,202,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,605,100.00	108,199,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,605,100.00	108,199,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,719,754,496.91	5,297,777,219.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,719,754,496.91	5,297,777,219.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,420,248,728.32	5,019,118,170.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,606,315,254.27	3,734,452,020.48
210101	Үндсэн цалин	1,806,395,096.46	2,431,292,713.97
210102	Нэмэгдэл	679,424,727.67	1,052,032,601.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,312,798.37	2,443,200.00
210104	Урамшуулал	118,182,631.77	248,683,505.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,243,011.08	465,679,400.29
210201	Тэтгэврийн даатгал	201,621,882.16	320,486,858.77
210202	Тэтгэмжийн даатгал	25,771,538.07	37,626,962.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,537,286.95	19,080,376.14
210204	Ажилгүйдлийн даатгал	5,028,590.54	17,697,038.74
210205	Эрүүл мэндийн даатгал	50,283,713.36	70,788,164.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,150,631.41	74,709,541.42
210301	Гэрэл, цахилгаан	12,212,584.46	16,262,746.49
210302	Түлш, халаалт	43,767,146.29	40,556,900.68
210303	Цэвэр, бохир ус	20,170,900.66	17,889,894.25
2104	Хангамж, бараа материалын зардал	62,350,417.20	35,363,983.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,030,017.00	-
210408	Бараа материал акталсны зардал	38,320,400.20	35,363,983.55
2105	Нормативт зардал	148,950.00	93,229,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	148,950.00	-
210502	Хоол, хүнс	-	93,229,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,231,800.00	16,756,550.00
210604	Урсгал засвар	6,231,800.00	16,756,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,239,000.00	37,307,847.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,115,200.00	4,864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,123,800.00	32,443,847.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	337,569,664.36	561,619,197.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,841,704.45	181,132,807.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,186,846.00	43,966,630.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	261,541,113.91	336,519,759.69

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	299,505,768.59	278,659,048.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	294,495,500.00	274,077,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	223,692,000.00	274,077,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,803,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,010,268.59	4,581,748.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,010,268.59	4,581,748.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	389,851,201.95	415,422,744.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	389,851,201.95	415,422,744.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,783,248,910.00	5,431,735,762.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,273,310.00	417,333,462.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,273,310.00	417,333,462.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,273,310.00	417,333,462.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,115,200.00	4,864,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,158,110.00	412,469,462.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,756,975,600.00	5,014,402,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,666,370,500.00	4,906,202,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,666,370,500.00	4,906,202,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,605,100.00	108,199,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,605,100.00	108,199,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,437,446,426.80	4,995,632,056.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,437,446,426.80	4,995,632,056.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,137,940,658.21	4,721,004,307.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,606,315,254.27	3,736,141,306.00
210101	Үндсэн цалин	1,806,395,096.46	2,432,942,531.49
210102	Нэмэгдэл	679,424,727.67	1,052,072,069.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,312,798.37	2,443,200.00
210104	Урамшуулал	118,182,631.77	248,683,505.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,243,011.08	463,990,114.77
210201	Тэтгэврийн даатгал	201,621,882.16	318,797,573.25
210202	Тэтгэмжийн даатгал	25,771,538.07	37,626,962.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,537,286.95	19,080,376.14
210204	Ажилгүйдлийн даатгал	5,028,590.54	17,697,038.74
210205	Эрүүл мэндийн даатгал	50,283,713.36	70,788,164.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,150,631.41	74,709,541.42
210301	Гэрэл, цахилгаан	12,212,584.46	16,262,746.49
210302	Түлш, халаалт	43,767,146.29	40,556,900.68
210303	Цэвэр, бохир ус	20,170,900.66	17,889,894.25
2105	Нормативт зардал	-	90,565,200.00
210502	Хоол, хүнс	-	90,565,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,444,200.00	28,908,310.00
210604	Урсгал засвар	9,444,200.00	28,908,310.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,649,000.00	37,307,847.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,115,200.00	4,864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,533,800.00	32,443,847.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,138,561.45	289,381,987.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,614,174.45	238,726,617.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,524,387.00	50,655,370.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	299,505,768.59	274,627,748.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	294,495,500.00	270,046,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	223,692,000.00	270,046,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,803,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,010,268.59	4,581,748.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,010,268.59	4,581,748.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	345,802,483.20	436,103,705.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	147,607,000.00	197,123,858.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,607,000.00	197,123,858.00
2200	Дотоод эх үүсвэрээр	147,607,000.00	197,123,858.00
222001	Тоног төхөөрөмж	147,607,000.00	197,123,858.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(147,607,000.00)	(197,123,858.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	198,195,483.20	238,979,847.78
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		425,950,465.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	425,950,465.99	664,930,313.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,374,640,377.37	4,554,871,580.94	88,138,084.49	9,017,650,042.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,374,640,377.37	4,554,871,580.94	88,138,084.49	9,017,650,042.80
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	415,422,744.54	415,422,744.54
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,374,640,377.37	4,554,871,580.94	503,560,829.03	9,433,072,787.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	71802	- ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ				
	80112	- НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ				

1	1220	Тусламжийн орлого	108,199,600.00	108,199,600.00		
2	122005	Төсвөөс санхүүжих	79,199,600.00	74,709,541.42	4,490,058.58	
3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,365,000.00	16,262,746.49	(3,897,746.49)	
4	210301	Гэрэл, цахилгаан	50,005,500.00	40,556,900.68	9,448,599.32	
5	210302	Түлш, халаалт	16,829,100.00	17,889,894.25	(1,060,794.25)	
6	210303	Цэвэр, бохир ус	29,000,000.00	28,908,310.00	91,690.00	
7	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,000,000.00	28,908,310.00	91,690.00	
8	210604	Урсгал засвар		4,581,748.58	(4,581,748.58)	
80226 - БАЙР АШИГЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ						
9	122005	Төсвөөс санхүүжих	12,663,900.00	12,663,900.00		100
10	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,667,100.00	12,663,550.00	3,550.00	99.97
11	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,667,100.00	12,663,550.00	3,550.00	99.97
80312 - СУРГАЛТ СЕМИНАР						
12	122005	Төсвөөс санхүүжих	12,182,400.00	12,182,400.00		
13	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,182,400.00	5,275,000.00	8,900.00	99.93
14	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,182,400.00	5,275,000.00	8,900.00	99.93
81605 - ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ						
15	1220	Тусламжийн орлого				
16	122005	Төсвөөс санхүүжих				
17	2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
18	210901	Бараа үйлчилгээний бусад зардал				
81801 - ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨР						
19	122005	Төсвөөс санхүүжих	226,521,000.00	226,521,000.00		100
20	2132	Бусад урсгал шилжүүлэг	226,521,000.00	270,046,000.00	(43,525,000.00)	119.21
21	213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	226,521,000.00	270,046,000.00	(43,525,000.00)	119.21
81816 - ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР						
22	122005	Төсвөөс санхүүжих	162,244,600.00	162,244,600.00		
23	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,244,600.00	162,244,400.00	199.00	100
24	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	162,244,600.00	162,244,400.00	199.00	100
81823 - БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ АЖИЛЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ						
25	1220	Тусламжийн орлого				
26	122005	Төсвөөс санхүүжих	37,991,500.00	37,991,500.00		100
27	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,146,400.00	5,199,800.00	37,946,600.00	12.05

28	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,146,400.00	5,199,800.00	37,946,600.00	12.05
81834 - БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ						
29	122005	Төсвөөс санхүүжих	4,171,034,100.00	4,171,034,100.00		100
30	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,833,446,000.00	3,464,233,963.48	369,212,036.52	90.37
31	210101	Үндсэн цалин	2,685,011,200.00	2,427,787,289.49	257,223,910.51	90.42
32	210102	Нэмэгдэл	1,144,135,600.00	992,143,568.84	151,992,031.16	86.72
33	210103	Унаа хоолны хөнгөлөлт		2,443,200.00	(2,443,200.00)	
34	210104	Урамшуулал	4,299,200.00	41,859,905.15	(37,560,705.15)	973.67
35	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	479,180,700.00	412,468,614.77	66,712,085.23	86.08
36	210201	Тэтгэврийн даатгал	325,842,900.00	283,762,873.25	42,080,026.75	87.09
37	210202	Тэтгэмжийн даатгал	38,334,500.00	33,505,262.38	4,829,237.62	87.4
38	210203	ҮОМШӨ-ний даатгал	19,167,200.00	17,019,576.14	2,147,623.86	88.8
39	210204	Ажилгүйдлийн даатгал	19,167,200.00	15,636,238.74	3,530,961.26	81.58
40	210205	Эрүүл мэндийн даатгал	76,668,900.00	62,544,664.26	14,124,235.74	81.58
41	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,289,700.00	69,014,304.10	34,275,395.90	66.82
42	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	103,289,700.00	69,014,304.10	34,275,395.90	66.82
43	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,604,400.00	105,909,736.94	11,694,663.06	90.06
44	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,949,000.00	55,254,366.94	11,694,633.06	82.53
45	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,655,400.00	50,655,370.00	30.00	100
81835 - СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ						
46	122005	Төсвөөс санхүүжих	232,676,500.00	232,676,500.00		100
47	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,676,500.00	232,676,500.00		100
48	210104	Урамшуулал	206,823,600.00	206,823,600.00		100
49	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,852,900.00	25,852,900.00		100
50	210201	Тэтгэврийн даатгал	17,580,000.00	17,580,000.00		100
51	210202	Тэтгэмжийн даатгал	2,068,200.00	2,068,200.00		100
52	210203	ҮОМШӨ-ний даатгал	1,034,100.00	1,034,100.00		100
53	210204	Ажилгүйдлийн даатгал	1,034,100.00	1,034,100.00		100
54	210205	Эрүүл мэндийн даатгал	4,136,500.00	4,136,500.00		100
81844 - ГҮНЗГИЙРҮҮЛСЭН БОЛОН ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТЫН ОРЧИН САЙЖРУУЛАХ						

55	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	205,102,200.00	267,632,399.00	62,530,199.00	130.49
56	2105	Норматив зардал	90,565,200.00	90,565,200.00		100
57	210502	Хоол, хүнс	90,565,200.00	90,565,200.00		100
58	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,571,400.00	108,727,200.00	5,844,200.00	94,90
59	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,571,400.00	108,727,200.00	5,844,200.00	94,90
81848 - СУРАХ БИЧГИЙН ТҮРЭЭС						
60	122005	Төсвөөс санхүүжих	4,864,000.00	4,864,000.00		100
61	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,864,000.00	4,864,000.00		100
62	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,864,000.00	4,864,000.00		100
81875 - СУРГУУЛИЙН НЭМЭЛТ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ						
63	122005	Төсвөөс санхүүжих	29,782,200.00	29,782,200.00		100
64	2108	Бараа үйлчилгээний бусад зардал	29,782,200.00	26,883,551.41	2,898,648.49	90.27
65	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,782,200.00	26,883,551.41	2,898,648.49	90.27
83602 - ЗГ БОЛОН ЗД-ЫН НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ХУВААРИЛСАН						
66	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	231,018,100.00	140,982,905.00	90,035,195.00	61.03
67	2101	Бараа үйлчилгээний бусад зардал	205,349,500.00	65,083,742.52	140,265,757.48	39.28
68	210101	Үндсэн цалин		5,155,242.00	(5,155,242.00)	-
69	210102	Нэмэгдэл	205,349,500.00	59,928,500.52	145,420,999.48	29.18
70	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,668,600.00	25,668,600.00		100
71	210201	Тэтгэврийн даатгал	17,454,700.00	17,454,700.00		100
72	210202	Тэтгэмжийн даатгал	2,053,500.00	2,053,500.00		100
73	210203	ҮОМШӨ-ний даатгал	1,026,700.00	1,026,700.00		100
74	210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,700.00	1,026,700.00		100
75	210205	Эрүүл мэндийн даатгал	4,107,000.00	4,107,000.00		100
83603-НЭМЭЛТ- ДЭЭД ШАТНЫ ТӨСВӨӨС ХУВААРИЛСАН						
76	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	3,854,200.00	3,854,158.00	42.00	100
77	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,854,200.00	3,494,150.00	360,050.00	90.66
78	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,854,200.00	3,494,150.00	360,050.00	90.66

79	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	425,930,465.99	(425,930,465.99)	
80	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	664,910,313.77	(664,910,313.77)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,807.3 мянган төгрөгийн алдаа^{1,2} зөрчил илэрснээс, 14,221.9 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 5,405.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 7,180.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

2024 оны санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

5.1 ТӨЛБӨРИЙН АКТ

Илрүүлэлт: Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын даргын 2024 оны 12 сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалыг үндэслэн 694.8 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.8-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.” гэж заасныг зөрчсөн байна.

Илрүүлэлт: Эрүүл мэндийн үзлэг оношилгооны жагсаалтад байхгүй үзлэгт хамруулж 2,040.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/238, А/340 "Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай" тушаалын хавсралттай нийцэхгүй байна.

Илрүүлэлт: 2023 оны төсвийн жилд олгох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа багшид 1,527.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7.1-д “төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тайлант онд 78 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 9,956.5 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-т "ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын 13.1-т "ажилтны ээлжийн амралтын цалинг ээлжийн амралт эдлэхээс өмнө олгоно. 3.2-т "Ээлжийн амралтаа хэсэгчлэн эдэлж байгаа ажилтны ээлжийн амралтын цалинг бүтнээр, эсхүл ээлжийн амралтыг хэсэгчлэн авч байгаа хугацаанд нь ногдох хэмжээгээр амрах тухай бүрд олгож болно" гэж заасныг зөрчсөн байна

5.2 АЛБАН ШААРДЛАГА

Илрүүлэлт: Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 1,544.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Илрүүлэлт: Байгууллагын удирдлагын тушаал шийдвэргүй багш нарт 136,605.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1-д "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,206.5 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Илрүүлэлт: Батлагдаагүй орон тоонд 1,654.6 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэж заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагатай холбоотой 7,180.3 мянган төгрөгийн өглөг үүсгэн ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д " хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Илрүүлэлт: Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 648,190.5 мянган төгрөгийн 6 тушаал шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 8.4-д "Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг ил тод, үнэн зөв, хугацаанд нь байршуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван дөрөвдүгээр сургууль	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван дөрөвдүгээр сургууль	10	26.8	4	14.2	4	5.4	2	7.2	-	-	-	-
Дүн	10	26.8	4	14.2	4	5.4	2	7.2				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ		1	1			1			